Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Мөст сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч, засаг дарга С.Баасандорж танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн сумын төсөвт байгууллагуудын түлээ нүүрсний худалдан авалт зарцуулалтад тавих дотоод хяналт, ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалт, бараа материалд орлогод авах зэрэг зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 18-наас 2021 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нарантуул гүйцэтгэв.

Мөст сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төрийн аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 1/22 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Мөст сумын засаг дарга нь Монгол улсын Үндсэн хууль болон УИХ, Засгийн газраас гарч буй хууль тогтоомжид нийцүүлэн төрийн үйлчилгээг ард иргэдэд хуулийн дагуу түргэн шуурхай, чанартай ил тод нээлттэйгээр хүргэх, тэгш хүргэж ажилгүйдэл, ядуурлыг бууруулан, хувь хүмүүс өрх гэрүүдэд өөрийгөө тэтгэн хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, тэдний бие бялдар, сэтгэл зүйн сайн сайхан байдлыг хамгаалах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд сумынхаа эдийн засаг, нийгмийн хөгжлийг эрчимжүүлж, байгаль орчин, бизнест ээлтэй ногоон хөгжлийн бодлого хэрэгжүүлэх
- Төрийн үйлчилгээг чанарын шинэ шатанд гаргаж, ард иргэдийнхээ амьдрах орчныг сайжруулах, аж амьдралыг дээшлүүлэх олон талт үйл ажиллагаа явуулах

### 3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Зэрэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Ховд аймгийн Засаг даргын дэргэдэх санхүү, дотоод аудитын албанаас 2020 онд Мөст сумын ТТЗ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Мөст сумын ТТЗ-ын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4 **Материаллаг байдал**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшнийг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Энэ нь материаллаг байдлыг үнэ цэнэ талаас нь авч үзэхийн тулд санхүүгийн тайлангийн хамгийн чухал хэсгүүд болох нийт орлогыг /өөрийн орлого, төсвийн санхүүжилт, татвар болон татварын бус орлого / сонгон авч үзлээ.

Төлөвлөлтийн үе шатанд 2019 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлангаас тооцсон бол гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн нийт орлого 2418264.0 мянган төгрөгөөр 1 хувиар тооцож 24182.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон болно.

### 3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 278708.0 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 114068.9 төгрөг болж, 164639.1 мянган төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл* *(/мянган төгрөг/)*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дунд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| ОНХС | 6,966.4 | 56,816.7 | 49,850.3 | 8.2 |
| СХС | 6,177.4 | 3,896.9 | (2,280.5) | (36.9) |
| Төрийн сан | 265,564.2 | 53,355.3 | (212,208.9) | 20.1 |
| **Дүн** | **278,708.0** | **114,068.9** | **(164,639.1)** | **40.9** |

*Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл* *(/мянган төгрөг/)*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дунд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Шим Ус ОНӨААТҮГ | 18.5 | 2989.3 | 2970.6 | 161.5 |
| Тээлийн Илч ОНӨААТҮГ | 836.9 | 4043.6 | 3206.9 | 83.1 |
| ОНХС | 54465.6 | 9926.8 | -44538.8 | -182.2 |
| СХС | 2336.7 | 12436.5 | 10099.8 | 188.0 |
| Төрийн сан | 153693.7 | 36904.5 | -116789.2 | 240.0 |
| **Дүн** | **211351.4** | **66300.7** | **-145050.7** | **0.98** |

*Эх сурвалж: Мөст сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 53355.3 мянган төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд байршиж байна.

### 3.5.2 Авлага

Авлага хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 237280.9 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 230430.5 мянган төгрөг болж, 6850.4 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №3 . Авлагын үлдэгдэл* */мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Ажиллагчидтай холбогдсон авлага | 3,014.1 | 348.3 | (2,665.8) |
| Байгууллагаас авах авлага | 6,120.0 | 1,413.5 | (4,706.5) |
| Хувь хүмүүсээс авах авлага | | 471.0 | 471.0 |
| Зээлийн хүүгийн авлага | 228,146.8 | 219,381.4 | (8,765.4) |
| Татвар, НДШ /ОНӨААТҮГ/ | | 300.0 | 300.0 |
| Татаас санхүүжилтийн авлага | | 8,516.3 | 8,516.3 |
| **Дүн** | 237,280.9 | 230,430.5 | (6,850.4) |

*Эх сурвалж: Мөст сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 219381.4 мянган төгрөгийн дараах авлага байна.

*Нийт авлагын дийлэнхийг сум хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн авлага эзэлж байгаа бөгөөд оны эхэнд 228146.8 мянган төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 10000.0 мянган төгрөгийн зээл олгож, 7719.5 мянган төгрөгийн зээл, зээлийн хүү эргэн төлөгдөж, өмнөх онд зээлийн хүү, алданги 18765.4 мянган төгрөгөөр илүү бүртгэсэнтэй холбоотой залруулга хийгдэж, оны эцэст 219381.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.*

*Сум хөгжүүлэх сангаас 2018-2019 онуудад олгосон 14 зээлдэгчийн 39400.0 мянган төгрөгийн зээлийн авлага нь хэвийн төлөгдөж, 2011-2017 онуудад олгосон 60 зээлдэгчтэй холбогдох 171500.0 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн авлага байгаа нь сангийн эргэцийг удаашруулж, хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна. Тухайн хугацаа хэтэрсэн 36 зээлдэгчтэй холбогдох авлагыг 2020 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр шүүх, хяналтын байгууллагад шилжүүлж ажилласан байна.*

*Хүснэгт №4 . Урьдчилгаа дансны үлдэгдэл* */мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Урьдчилж гарсан зардал | 184,509.5 | 220,704.5 | 36,195.0 |
| Цалингийн урьдчилгаа | 4,299.0 | | (4,299.0) |
| **Дүн** | 188,808.5 | 220,704.5 | |

*Эх сурвалж: Мөст сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

*Урьдчилгаа данс өмнөх оноос 36195.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайланд оны эцэст сангийн хөрөнгөөр хийх ажлуудыг шууд гэрээ байгуулснаас нэмэгдсэн байна.*

*Аудитын илрүүлэлт:*

- *ОНХС-ийн хөрөнгөөр 2020 онд хийгдсэн 6 ажилд 16695.0 мянган төгрөгийн урьдчилгаа олгож хүлээн аваагүй санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй,*

### 3.5.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 80766.5 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 132004.5 мянган төгрөг болж, 51238.0 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 5. Бараа материалын үлдэгдэл* */мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Тусгай зориулалтын материал | | 55.0 | 55.0 |
| Эм боох материал | | 2,178.9 | 2,178.9 |
| Бичиг хэргийн материал | 793.6 | 1,277.2 | 483.6 |
| Аж ахуйн материал | 5,661.6 | 8,617.8 | 2,956.2 |
| Сэлбэг хэрэгсэл | 1,432.0 | 185.5 | (1,246.5) |
| Түлш, шатах тослох материал | 17,629.1 | 22,094.3 | 4,465.2 |
| Барилгын засварын материал | 1,700.2 | 800.3 | (899.9) |
| Хүнсний материал | 7,029.0 | 10,880.3 | 3,851.3 |
| Бусад хангамжийн материал | 40,824.0 | 79,818.2 | 38,994.2 |
| Мал амьтад | 5,697.0 | 6,097.0 | 400.0 |
| **Дүн** | 80,766.5 | 132,004.5 | 51,238.0 |

*Эх сурвалж: Мөст сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Бараа материалын дансны үлдэгдэл Хүүхдийн цэцэрлэгийн 488262 мянган төгрөг, ЗДТГазар 1645.2 мянган төгрөгөөр тус тус буурч , ерөнхий боловсролын сургуулийн бараа материал 49150.8, Соёлын төв 5891.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд түлээ, нүүрс болон хүнсний материал нөөцөлсөнтэй холбоотой байна

*Аудитын илрүүлэлт:*

- *Сумын ОНХС-ийн хөрөнгөөр тайланд онд 600 ширхэг пресс өвс бэлтгэсэн сумын ЗДТГ-ын эд хариуцагчид хүлээлгэн өгсөн санхүүгийн тайланд тусгаагүй орхигдуулсан,*
- *Сумын хэмжээний төсөвт байгууллагуудын түлээ нүүрс, хүнсний бараа материалд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, зарцуулалтад тавих дотоод хяналт хэрэгжилт хангалтгүй,*
- *Сургууль, Цэцэрлэгийн хүүхдийн хоолыг норм нормативын дагуу зарцуулаагүй, хүнсний бүтээгдэхүүний шинжилгээний бичиггүй, хүнс нийлүүлэх гэрээ байхгүй, мах, сүү нь гарал үүслийн бичиггүй,*

*Дээрх алдаа зөрчлийг төсвийн шууд захирагч нарын тайланд тусган шийдвэрлэснийг Төсвийн төвлөрүүлэн захирагч дотоод хяналт хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байна.*

### 3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 6762452.3 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 6941856.2 мянган төгрөг болж, 179403.9 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 6. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл* */мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Барилга байгууламж, орон сууц | 5,472,381.9 | 5,588,407.3 | 116,025.4 |
| Тээврийн хэрэгсэл | 127,520.9 | 122,130.9 | (5,390.0) |
| Машин тоног төхөөрөмж | 642,168.5 | 622,805.8 | (19,362.7) |
| Тавилга эд хогшил | 274,367.5 | 310,391.7 | 36,024.2 |
| Түүх соёлын дурсгалт зүйл | 12,118.9 | 12,118.9 | - |
| Дуусаагүй барилга байгууламж | | 49,200.0 | 49,200.0 |
| Номын фонд | 40,927.0 | 43,834.0 | 2,907.0 |
| Бусад үндсэн хөрөнгө | 2,559.5 | 2,559.5 | - |
| Программ хангамж | 34,634.1 | 34,634.1 | - |
| Бусад биет бус хөрөнгө | 155,774.0 | 155,774.0 | - |
| **Дүн** | 6,762,452.3 | 6,941,856.2 | 179,403.9 |

*Эх сурвалж: Мөст сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 35400.9 мянган төгрөгийн бэлтгэсэн, үнэ төлбөргүй хандиваар аймгийн хөрөнгө оруулалтаар 49200.0, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 128393.1 мянган төгрөгийн ажил хийгдсэнтэй холбоотой нэмэгдсэн, акталсан 205517.4 мянган төгрөгөөр хасагдсан байна.

Аймгийн хөрөнгө оруулалтаар тайлант онд Ерөнхий боловсролын сургуульд 49200.0 мянган төгрөгөөр гал тогооны засварын ажил онд дамжуулан хийгдсэнтэй холбоотой дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй байна.

*Аудитын илрүүлэлт:*

- *ОНХС-ийн хөрөнгөөр худалдан авсан 16695.0 мянган төгрөгийн* тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг санхүүгийн тайланд тусгаагүй,

### 3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 20630.2 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 14527.9 мянган төгрөг болж, 6102.3 мянган төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №.7 . Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өссөн+ Буурсан - | Дунд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| **Богино хугацаат өр төлбөр дүн** | | | | |
| Ажилчидтай холбогдсон өглөг | 9007.4 | 139.7 | -8867.7 | 1.6 |
| Бараа үйлчилгээний зардлын өглөг | 2832 | 132 | -2700.0 | 4.7 |
| Байгууллагад төлөх өглөг | 5963.9 | 12560.2 | 6596.3 | 210.6 |
| Хувь хүмүүст төлөх өглөг | 2826.9 | 1696 | -1130.9 | 60.0 |
| **Нийт дүн** | 20630.2 | 14527.9 | -6102.3 | 70.4 |

*Эх сурвалж: Мөст сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд бусад бага дүнтэй өглөгүүд дараа тайлангийн хугацаанд бүрэн барагдах боломжтой өглөгүүд байна.

### 3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 5847844.4 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 5882419.7 мянган төгрөг болж, 34575.3 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 8. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт/+/, бууралт /-/ |
|---|---|---|---|
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 3,305,184.7 | 3,305,184.7 | - |
| Хуримтлагдсан үр дүн | 529,506.9 | 569,719.0 | 40,212.1 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,013,152.8 | 2,007,516.0 | (5,636.8) |
| **Дүн** | 5,847,844.4 | 5,882,419.7 | 34,575.3 |

*Эх сурвалж: Мөст сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 2007516.0 мянган төгрөг болж 5636.8 мянган төгрөгөөр өссөн нь ЗДТГазар, Сургууль тайланд хөрөнгө акталснаас шалтгаалжээ.

Эздийн өмчийн бусад хэсэг данс 3305184.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. шалтгаалжээ.

Хуримтлагдсан үр дүн 569719.0 мянган төгрөг болж 40212.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 53456.9 мянган төгрөгийн ашигтай байна.

Бодлогын өөрчлөлт алдааны залруулга дансанд акталсан хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл данс, СХС-ийн алданги, хүүг өмнөх онд зөрүүтэй тооцсоноос шалтгаалан бүртгэгдсэн 13244.8 мянган төгрөгийн алдааны залруулга байна.

### 3.5.10 Орлогын данс

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар татварын орлого 273631.3, татварын бус орлого 221.6, орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих орлого 34784.5 мянган төгрөгөөр тус тус буурсан, үнэ төлбөргүй орлого 179875.7, тусгай шилжүүлгийн санхүүжилт 179875.7, орон нутгаас олгох санхүүжилт 202950.4, нэмэлт санхүүжилтийн орлого 17985.0, аймгаас олгох санхүүгийн дэмжлэг 78627.6, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого 8240.9 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 9 . нийт орлогын гүйцэтгэл* */мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | 2,972,750.0 | 3,344,521.9 | 371,771.9 |
| Татварын орлого | 353,533.9 | 79,902.6 | (273,631.3) |
| Татварын бус орлого | 5,642.3 | 5,420.7 | (221.6) |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 162,259.3 | 342,135.0 | 179,875.7 |
| Тусламжийн орлого | | | - |
| Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,222,681.1 | 1,415,410.8 | 192,729.7 |
| Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 535,167.4 | 738,117.8 | 202,950.4 |
| Нэмэлт санхүүжилтийн орлого | 103,233.2 | 121,218.2 | 17,985.0 |
| Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 131,056.7 | 96,272.2 | (34,784.5) |
| Орон нутгийн төсөвт байгууллага төвлөрүүлэх шилжүүлэг | 679.5 | 8,920.4 | 8,240.9 |
| Урсгал үйл ажиллагааны санхүүжилт/аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/ | 458,496.6 | 537,124.2 | 78,627.6 |

### 3.5.11 Зардлын данс

Нийт зардал өмнөх оноос 490570.3 мянган төгрөгөөр буюу 17.6 хувиар өссөн нь өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, шимтгэлийн зардал, хангамж, бараа материалын зардал, урсгал шилжүүлэг, хөрөнгийн зардлууд тус тус өссөн, байр ашиглалттай холбоотой урсгал шилжүүлэг, нормативт зардал, томилолт, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардлууд буурсан байна.

*Хүснэгт № 10 . Зарлагын гүйцэтгэл* */мянган төгрөг/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|---|
| | 2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 2,787,093.6 | 3,277,663.9 | 490,570.3 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,241,328.9 | 1,443,665.0 | 202,336.1 |
| 2102 | Ажил олгогчоос даатгалд төлөх | 161,297.6 | 181,512.8 | 20,215.2 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 90,657.3 | 84,213.8 | (6,443.5) |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 45,838.7 | 55,458.2 | 9,619.5 |
| 2105 | Нормативт зардал | 101,640.2 | 44,649.4 | (56,990.8) |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 7,568.2 | 7,712.8 | 144.6 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 10,847.2 | 2,686.6 | (8,160.6) |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 38,482.4 | 26,502.3 | (11,980.1) |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 356,463.7 | 323,571.5 | (32,892.2) |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 635,749.6 | 956,109.0 | 320,359.4 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 97,219.8 | 151,582.5 | 54,362.7 |

Зардлын данстай холбоотой 56323.1 мянган төгрөгийн түлээ, нүүрсний зарцуулалтад тавих дотоод хяналт хэрэгжүүлээгүй зөрчил илэрлээ.

*Аудитын илрүүлэлт:*

- *Ерөнхий боловсролын сургуульд 33744.7 мянган төгрөгийн түлээ, нүүрс, ,*
- *Хүүхдийн цэцэрлэг 6545.6 мянган төгрөгийн түлээ, нүүрс,*
- *Соёлын төв 2575.0 мянган төгрөгийн түлээ нүүрсний зарцуулалтыг халаалтын улирлад 1 өдөрт хэчнээн хэмжээний нүүрс, түлээ зарцуулах норм нормтавт тогтоогүйгээс зарцуулалтад тавих хяналт сул байна.*
- *Сумын хэмжээний төсөвт байгууллагууд түлээ нүүрсийг худалдан авах талаар тендер зохион байгуулаагүй, худалдан авах гэрээгүй зөрчил илэрлээ.*

### 3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт**

Мөст сумын ИТХ-ын 2020 оны орон нутгийн төсөв батлах тухай 21 дугаар тогтоолд Мөст сумын Төвлөрүүлэн захирагчийн тайлант онд 43906.8 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 80817.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 184 хувиар биелүүлсэн байна.

*Хүснэгт 11 . Сумын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл* */мянган төгрөг/*

| Орлогын ангилал | 2020 оны | | Зөрүү |
|---|---|---|---|
| | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | |
| | 43,906.8 | 80,817.4 | 36,910.6 |
| Нийт орлого ба тусламжийн дүн | 43,906.8 | 80,817.4 | 36,910.6 |
| Татварын орлого | 42,906.8 | 79,902.6 | 36,995.8 |
| Орлогын албан татвар | 9,925.0 | 34,084.6 | 24,159.6 |
| Хувь хүний орлогын албан татвар | 9,925.0 | 34,084.6 | 24,159.6 |
| Үйл ажиллагааны орлого | 1,000.0 | 6,659.4 | 5,659.4 |
| Шууд бус орлого | 8,925.0 | 27,425.1 | 18,500.1 |
| Хөрөнгийн албан татвар | 28,824.8 | 32,447.1 | 3,622.3 |
| Бууны албан татвар | 2,824.8 | 2,987.5 | 162.7 |
| Иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого | 26,000.0 | 29,459.6 | 3,459.6 |
| Бусад татвар, төлбөр, хураамж | 4,157.0 | 13,371.0 | 9,214.0 |
| Бусад нийтлэг төлбөр, хураамж | 3,129.0 | 8,944.8 | 5,815.8 |
| Улсын тэмдэгтийн хураамж | 1,764.0 | 2,783.9 | 1,019.9 |
| Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны | 300.0 | 4,810.0 | 4,510.0 |
| Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 1,065.0 | 1,350.9 | 285.9 |

| | | | |
|---|---|---|---|
| Газрын төлбөр | | 273.2 | 273.2 |
| Газрын төлбөр | 0.00 | 273.2 | 273.2 |
| Байгалийн нөөц ашигласны төлбөр | 1,028.0 | 4,153.0 | 3,125.0 |
| Ус, рашааны нөөц ашигласны төлбөр | 428.0 | 1,800.0 | 1,372.0 |
| Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр | 600.0 | 2,353.0 | 1,753.0 |
| Татварын бус орлого | 1,000.0 | 914.8 | (85.2) |
| Торгуулийн орлого | 1,000.0 | 914.8 | (85.2) |

*Эх сурвалж: Мөст сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

## Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2376398.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2376398.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 70135.3 мянган төгрөгөөр бууруулж 2306263.4 мянган төгрөгөөр баталсан байна.

## Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрт зориулан 2306263.4 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2061984.2 мянган төгрөгийг урсгал зардалд, 244279.2 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1415410.8 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих, 677303.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 43105.0 төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлого, 170444.3 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр тусгай шилжүүлгээс 1334835.7, орон нутгаас 670363.9, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 9832.1, урьд оны үлдэгдлээс 157300.6 мянган төгрөг нийт 2172332.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, орон нутгийн төсөвт 8920.4, аймгийн төсөвт 183248.2 бүгд 192168.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт №.12. Санхүүжилтийн төлөвлөгөө, гүйцэтгэл* *[/мянган төгрөг/]*

| Д/д | Байгууллагын нэр | Нийт төлөвлөгөө | | | Гүйцэтгэл | | | Зөрүү | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Санхүүжилт | Өөрийн орлого | нийт | Санхүүжилт | өөрийн орлого | Нийт | | |
| 1 | ЗДТГ | 396,969.7 | 605.0 | 397,574.7 | 394,971.8 | 649.5 | 395,621.3 | (1,953.4) | татан төвлөрүүлсэн |
| 2 | ИТХ | 51,484.4 | - | 51,484.4 | 50,122.9 | - | 50,122.9 | (1,361.5) | татан төвлөрүүлсэн |
| 3 | Сум хөгжүүлэх сан | | 46,177.3 | 46,177.3 | | 7,719.6 | 7,719.6 | (38,457.7) | СХС зээлийн эргэн төлөлт төлөвлөгдсөн хэмжээнд бүрдээгүй |
| 4 | ОНХС | 244,279.2 | - | 244,279.2 | 237,312.8 | 315.0 | 237,627.8 | (6,651.4) | Төлөвлөгдсөн төсөл хөтөлбөрийн зардал санхүүжүүлээгүйтэй холбоотой мөнгө үлдсэн |
| | **ОНБ-дын дүн** | 692,733.3 | 46,782.3 | 739,515.6 | 682,407.5 | 8,684.1 | 691,091.6 | (48,424.0) | |
| 5 | ЕБСургууль | 1,182,793.6 | 500.0 | 1,183,293.6 | 1,134,062.1 | 500.0 | 1,134,562.1 | (48,731.5) | татан төвлөрүүлсэн |
| 6 | Хүүхдийн цэцэрлэг | 298,129.8 | - | 298,129.8 | 266,286.1 | - | 266,286.1 | (31,843.7) | татан төвлөрүүлсэн |
| 7 | Соёлын төв | 83,324.4 | 2,000.0 | 85,324.4 | 79,744.4 | 648.0 | 80,392.4 | (4,932.0) | Ковид-19 цар тахалтай холбоотой өөрийн орлого бүрэн бүрдээгүй |
| | **ТЗШ дүн** | 1,564,247.8 | 2,500.0 | 1,566,747.8 | 1,480,092.6 | 1,148.0 | 1,481,240.6 | (85,507.2) | |
| | **Нийт дүн** | 2,256,981.1 | 49,282.3 | 2,306,263.4 | 2,162,500.1 | 9,832.1 | 2,172,332.2 | (133,931.2) | |

Үндсэн үйл ажиллагааны орлого 9832.1 мянган төгрөгөөр бүрдүүлж, батлагдсан төсвөөс 39450.2 мянган төгрөгөөр тасарсан нь СХС-гийн зээлийн эргэн төлөлтөөс бүрдүүлэх орлогыг бүрэн төвлөрүүлээгүйтэй холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын 25 төсөл, арга хэмжээнд 260539.2 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас 237627.8 сая төгрөгийн санхүүжилт олгож, орон нутгийн хөгжлийн сангийн дансанд 56816.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2124762.4 мянган төгрөг нь 92.1 хувьтай байгаа нь сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн төлөвлөгөө тасарсантай холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын 25 төсөл, арга хэмжээнд 244279.2 төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 237312.8 мянган төгрөгийн санхүүжилт олгож, барьцаа, захиалагчийн хяналтын зардалд 4500.0 мянган төгрөгийг сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн байна.

## Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Онцгой байдлаас Ковид-19 цар тахлын зардал, , урсгал зардал, статистикийн судалгааны зардал, БОНС-ийн барьцаа, аймгийн хөрөнгө оруулалтаас, Онцгой байдлаас томилолтын зардал, сурах бичгийн түрээсийн орлого, Дэлхийн байгаль хамгаалах сан, туслах үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 121218.2 сая, төгрөгийн орлогыг бүрдүүлж, орон нутгийн төсөвт 8516.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт №.13* *Нэмэлт данс* /мянган.төгрөг/

| | | Бусад орлого | Нийт | |
|---|---|---|---|---|
| 1 | ЗДТГ | 64,032.3 | 64,032.3 | Аймгийн Онцгой байдлаас Ковид-19 цар тахлын зардал, , урсгал зардал, статистикийн судалгааны зардал, БОНС-ийн барьцаа, аймгийн хөрөнгө оруулалтаас, Онцгой байдлаас томилолт, |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 3 | ЕБСургууль | 56,435.5 | 56,435.5 | Аймгийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр гал тогооны засвар, Дэлхийн байгаль хамгаалах сангаас , туслах үйл ажиллагааны орлого, ном,сурах бичгийн түрээсийн орлого |
| 4 | Цэцэрлэг | 750.4 | 750.4 | Татаас санхүүжилт |
| **Нийт дүн** | | 121,218.2 | 121,218.2 | |

Үнээс үндсэн цалин, шимтгэлд, хангамж бараа материалын зардал, эд хогшил, урсгал засварын зардал, томилолт, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал, бусад бараа үйлчилгээний зардалд зарцуулсан байна.

### 3.7 **Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 145 мэдээллээс 144 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож, дараа жилийн төсвийн төслийн мэдээллийг байршуулаагүй байна.

### 3.8. **ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид акт, албан шаардлага өгөгдөөгүй, 24799.7 мянган төгрөгийн 4 алдаа зөрчилд зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт 60 хувьтай хэрэгжсэн байна.

*Хүснэгт 14* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

| **Үзүүлэлт** | **Өмнөх оны илрүүлэлт** | | **Биелэлт** | | **Биелэгдээгүй** | | **Хэрэгжилтийн хувь** |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Хувь** |
| Зөвлөмж | 4 | 24,799.7 | 3 | 9,799.7 | 1 | 15,000 | 60% |
| **Нийт** | 4 | 24,799.7 | 3 | 9,799.7 | 1 | 15,000 | 60% |

### 3.9 **Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 4 төсвийн байгууллага, 2 тусгай сан, нийт 7 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагыг аудитад хамруулан дүгнэлт гаргаж, 3 тайланг түүвэрт хамруулсан байна.

*Хүснэгт №15. Аудитад хамрагдсан хэлбэр, аудитын дүгнэлт*

| **№** | **Байгууллагын ангилал, нэр** | | **Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр** | | | **Аудитын дүгнэлт** | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | **Санал дүгнэлт гаргасан** | **Түүвэрт** | **Гэрээгээр хийлгэсэн** | **Зөрчилгүй** | **хязгаарлалттай** |
| 1 | Төсвийн шууд захирагч | ЗДТГ | 1 | | | 1 | |
| 2 | | ИТХ | | 1 | | | |
| 3 | | Сургууль | 1 | | | | 1 |
| 4 | | Цэцэрлэг | 1 | | | | 1 |
| 5 | | Соёлын төв | 1 | | 1 | 1 | |
| 6 | ОНТС | СХС | | 1 | | | |
| 7 | | ОНХС | | 1 | | | |
| **Дүн** | | | 4 | 3 | 1 | 2 | 2 |

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”-2, “Хязгаарлалттай” 2, нийт 4 дүгнэлт гаргасан байна.

***Санхүүгийн нэгтгэсэн тайлангаар илэрсэн алдаа, зөрчил:***

Аудитаар нийт 360686.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 33390.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 114267.0 мянган төгрөгийн алдааг арилгах 1 албан шаардлага, 213029.3 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

*Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга*

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- ОНХС-ийн хөрөнгөөр ЗДТГазар болон ИТХ, халуун ус, Цэцэг гол багийн худгийн мотор, цэцэрлэгт хүрээлэнгийн тоглоом 9000.0, байгаль хамгаалагчид авсан мотоцикл 2000.0 бүгд 16695.0 мянган төгрөгийг хөрөнгө бэлтгэхээр урьдчилан олгосон авлагаар бүртгээгүй,
- ОНХС-ийн 2020 оны санхүүгийн тайлангийн тайлант үеийн үр дүнг 16695.0 мянган төгрөгөөр зөрүүтэй дутуу тайлагнажээ.

***Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага***

Тайлант онд ОНХС-аар хийгдэх 25 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ сумын иргэдээс санал авч эрэмбэлэгдээгүй 10 ажил, хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлсэн, өмнөх оны санхүүгийн тайланд авлагаар тусгагдсан УТХО-оор хийгдсэн замын зураг төсвийн үнэ, айл өрхүүдээс авах банзны үнэтэй олгосон авлагыг барагдуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 60 дугаар зүйлийн 60.3.6-д “орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх”, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны 228 дугаар журмын 3.1.2-д "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх;", 3.1.4-д “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтад сум, дүүргийн төвөөс алслагдсан баг, хорооны иргэдийн хамгийн олон саналыг авч эрэмбэлэгдсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг заавал багтаах”, 3.11.3-д “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх”, 4.2-д "ОНХС-ийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулж үл болно", 4.2.5-д "Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагаас бусад улсын төсвийн байгууллагын хөрөнгийн зардал;", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөрийг үүсгэхгүй байх", 16.5.1-д" төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй, аудитын “тохиолдсон байх”, “үнэлгээ”, “толилуулга ба тодруулга”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх

Төвлөрүүлсэн захирагчид 196334.3 мянган төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 3 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

***Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн алдаа, зөрчил***

Мөст сумын ТТЗ-ын нэгтгэлд хамрагдсан төсвийн шууд захирагчдын 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 528022.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч, 150118.5 мянган төгрөгийн алдааг залруулсан байна.

Залруулагдаагүй 377904.2 мянган төгрөгийн алдаа зөрчлөөс 11884.7 мянган төгрөгийн 3 алдаа зөрчилд төлбөрийн акт, 139843.1 мянган төгрөгийн 4 алдаа зөрчилд албан шаардлага, 226176.4 мянган төгрөгийн 12 алдаа зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна. Нийт алдаа зөрчил, шийдвэрлэлтийг хүснэгтээр харуулбал:

*Хүснэгт № 16. ТШЗ-ын нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн нийт алдаа зөрчил, шийдвэрлэлт /мянган.төгрөг/*

| № | Байгууллагын ангилал, нэр | | нийт илэрсэн алдаа | | Үүнээс залруулсан | | Залруулаагүй | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тоо | дүн | тоо | дүн | тоо | дүн |
| 1 | Төсвийн шууд захирагч | ЗДТГ | 4 | 11,065.8 | 1 | 6,376.0 | 3 | 4,689.8 |
| 2 | | ИТХ | - | - | | | | |
| 3 | | Сургууль | 10 | 129,261.4 | 5 | 99,583.8 | 5 | 29,677.6 |
| 4 | | Цэцэрлэг | **8** | **41,691.6** | 4 | 9,022.1 | 4 | 32,669.5 |
| 5 | | Соёлын төв | **5** | **2,012.6** | 2 | 1,746.6 | 3 | 266.0 |
| 6 | ОНТС | СХС | - | - | | | | |
| 7 | | ОНХС | **7** | **427,500.7** | 2 | 33,390.0 | 5 | 394,110.7 |
| | **Дүн** | | 34 | 611,532.1 | 14 | 150,118.5 | 20 | 461,413.6 |

| № | Байгууллагын ангилал, нэр | | Залруулаагүй алдаа, зөрчил | | Үүнээс: Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | | тоо | дүн | тоо | дүн | тоо | дүн | тоо | дүн |
| 1 | Төсвийн шууд захирагч | ЗДТГ | 3 | 4,689.8 | - | - | - | - | 3 | 4,689.8 |
| 2 | | ИТХ | 0 | - | - | - | - | - | - | - |
| 3 | | Сургууль | 5 | 29,677.6 | 1 | 4,673.3 | 1 | | 3 | 25,004.3 |
| 4 | | Цэцэрлэг | 4 | 32,669.5 | 1 | 7,093.4 | 2 | 25,576.1 | 1 | - |
| 5 | | Соёлын төв | 3 | 266.0 | 1 | 118.0 | - | - | 2 | 148.0 |
| 6 | ОНТС | СХС | 0 | - | - | - | - | - | - | - |
| 7 | | ОНХС | 5 | 394,110.7 | - | - | 1 | 197,776.4 | 3 | 196,334.3 |
| | **Дүн** | | 20 | 461,413.6 | 3 | 11884.7 | 4 | 223352.5 | 12 | 226,176.4 |

### 3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар ОНХС-ийн төлөвлөлт, худалдан авах ажиллагааны талаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

## 4. **МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### 1. ***Дотоод хяналттай холбоотой асуудал***

1.1. *Илрүүлэлт:* Сумын төсөвт байгууллагуудын түлээ, нүүрсний зарцуулалтад тавих дотоод хяналт хэрэгжүүлэх талаар өмнөх аудитаар зөвлөмж өгөгдсөн хэрэгжүүлээгүй, тус байгууллага нь 1 өдөрт хэчнээн нүүрс түлээ зарцуулалдаг норм норматив тогтоогоогүй, худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй зөрчил илэрлээ.

1.2. *Эрсдэл:* Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах, зах зээлийн үнээс өндөр үнээр худалдан авах, хөрөнгө дутах,

1.3. *Өгсөн зөвлөмж*: Засгийн газрын 311 дүгээр тогтоолын 1.5-д “энэ журмын 1.4-т зааснаас бусад тохиолдолд “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ыг тухайн байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө”, 3.5-д “дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь хяналтын ажлын дүн, авсан арга хэмжээний талаар улиралд 1 доошгүй удаа тухайн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын хурлаар хэлэлцүүлж, шаардлагатай бол шийдвэр гаргуулан хамт олонд мэдээлнэ”, 3.6-д ”дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэнэ” гэсэн заалтуудыг мөрдөөгүй тул дотоод хяналтын баг томилон дээрх алдаа арилгуулан ажиллах

1.4. <u>Байгууллагаас өгсөн хариу тайлбар:</u> Хүлээн зөвшөөрсөн

2.1 **. ОНХСангийн зарцуулалттай холбоотой асуудал**

2.1.***1. Илрүүлэлт:*** *ОНХС-ийн хөрөнгөөр тайлант Сургуулийн дотуур байрны дээврийн засварын 90000.0 мянган төгрөгийн ажилд цахим тендер зарлаагүй шууд гэрээ байгуулсан, "Үгтах хаалга", Соёмбо төв цэг" хийх 41394.3 мянган төгрөгийн ажлыг харьцуулалт хийгээгүй, ажлуудын техник хяналтын зардал, зургийн үнэ, магадалшгүй ажлын зардлуудыг тооцон гэрээнд тусгаагүй, сумын ЗДТГ-ын бичиг хэрэг, гэрэл цахилгааны өр төлбөрт 2616.9 мянган төгрөгийг төлсөнтэй холбоотой 134011.2 мянган төгрөгийн зөрчил дутагдал илэрлээ.*

2.1.***2. Эрсдэл:*** Сангийн хөрөнгийн үр өгөөж буурах, төсөвт зураг төсвийн өр үүсэх, холбогдох хууль дүрэм журам хэрэгжихгүй байх, зориулалт бусаар зарцуулах

<u>3.1.3 ***Өгсөн зөвлөмж***:</u> *Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны 228 дугаар журмын 3.1.2-д "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх;", 4.2-д "ОНХС-ийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулж үл болно", 4.2.5-д "Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагаас бусад улсын төсвийн байгууллагын хөрөнгийн зардал;", 3.1.2-д "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх;", 4.2-д "ОНХС-ийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулж үл болно", 4.2.5-д "Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагаас бусад улсын төсвийн байгууллагын хөрөнгийн зардал;" гэсэн заалтыг мөрдөх, захиалагч барилгын ажлын зардал ТЭЗҮ, зураг төсвийн үнэ, захиалагчийн хяналтын зардал, чанарын баталгаат хугацааны барьцаа тус тусын дансанд холбогдох баримт, материалыг үндэслэн шилжүүлж, тооцоог хийж байх.*

<u>2.1.***4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар***:</u> *Үйлчлүүлэгч байгууллага хүлээн зөвшөөрсөн*

3.**1 . Бараа материалын данстай холбоотой асуудал**

3.***1.1. Илрүүлэлт:*** *Тайлант онд сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 600 ширхэг пресс өвсийг 6000.0 мянган төгрөгөөр худалдан авсан ЗДТГ-ын эд хариуцагч хүлээлгэн өгсөн санхүүгийн тайлан балансад тусгаагүй зөрчил дутагдал илэрлээ.*

3.***1.2. Эрсдэл:*** Сангийн хөрөнгийн үр өгөөж буурах, хөрөнгө эзэнгүйдэх,

<u>3.1.3 ***Өгсөн зөвлөмж***:</u> *2021 оны 1 дүгээр улиралд багтаан ЗДТГазарт орлого авч зарцуулалтад хяналт тавин ажиллах*

<u>3.***1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар***:</u> *Үйлчлүүлэгч байгууллага хүлээн зөвшөөрсөн*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 6 дугаар сарын 15-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Хавсралт

## 5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| | |
|---|---|
| **Огноо:** | 2020 |
| **Аудитын нэр:** | Мөст сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан |
| **Аудитын код:** | ХОА-2021/14/СТА-ТТЗ |
| **Шалгагдсан байгууллагын нэр:** | Мөст сумын Засаг дарга |
| **Мянган төгрөгөөр** | |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| 1 | ОНХС-гийн авлага бүртгээгүй, тайлант оны үе дүн зөрүүтэй илэрхийлсэн | 33390.0 | Залруулга хийх | Засаг дарга, санхүүгийн албаны дарга | С.Баасандорж, Б.Нямаа |
| 2 | ОНХС-аас 2020 онд эрэмбэлэгдээгүй 10 ажил, хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлсэн, өмнөх онд УТХО-оор хийгдсэн замын зураг төсвийн үнэ, айл өрхүүдээс авах банзны үнийг авлагаар тусгагдсан авлагыг барагдуулаагүй | 197776.4 | Албан шаардлага | Засаг дарга, санхүүгийн албаны дарга | С.Баасандорж, Б.Нямаа |
| 3 | Угтах хаалга", Соёмбо төв цэг" ажлыг харьцуулалт хийгээгүй, ажлуудын техник хяналтын зардал, зургийн үнэ, магадалшгүй ажлын зардлуудыг тооцон гэрээнд тусгаагүй, сумын ЗДТГ-ын бичиг хэрэг, гэрэл цахилгааны өр төлбөр төлсөн | 134011.2 | Зөвлөмж өгөх | Засаг дарга, санхүүгийн албаны дарга | С.Баасандорж, Б.Нямаа |
| 4 | Сумын төсөвт байгууллагуудын түлээ, нүүрсний зарцуулалтад тавих дотоод хяналт хэрэгжүүлэх талаар өмнөх аудитаар зөвлөмж өгөгдсөн хэрэгжүүлээгүй, тус байгууллага нь 1 өдөрт хичнээн нүүрс түлээ зарцуулалдаг норм норматив тогтоогоогүй, худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй | 56323.1 | Зөвлөмж өгөх | Засаг дарга, санхүүгийн албаны дарга | С.Баасандорж, Б.Нямаа |
| 5 | Тайлант онд сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 600 ширхэг пресс өвсийг худалдан авч, ЗДТГ-ын эд хариуцагч хүлээлгэн өгсөн санхүүгийн тайлан балансад тусгаагүй | 6000.0 | Зөвлөмж өгөх | Засаг дарга, санхүүгийн албаны дарга | С.Баасандорж, Б.Нямаа |
| | **Дүн** | 427500.7 | | | |

**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**